

УЛААНСАН ХК

2026.03.20

№ 26/4

Улаанбаатар хот

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-д

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
мэдэгдлийг хүргүүлэх нь*

Улаансан ХК (цаашид “Компани” гэх)-ийн 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолын дагуу компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулахаар шийдвэрлэсэн тул дараах баримт материалыг хүргүүлж байна. Үүнд:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын нэгдүгээр хавсралтаар баталсан хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл;
2. Улаансан ХК-ийн 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол, түүний хавсралтаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын баримт материал.

Хавсралт: 11 хуудас

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



П.БАТБАЯР

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний
одрийн 377 дугаар тогтоолоор баталсан "Хувьцаат компанийн хувьцаа
эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын нэгдүгээр Хавсралт



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр	Улаансан ХК
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэр, 17 давхар
Хурал хуралдах өдөр, цаг	2026 оны 4 сарын 29-ний өдөр, 14:00 цаг
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сэнтрал Тауэрийн 17 давхарт
Хурлын төрөл	Ээлжит
Хурал зарлагч	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2026 оны 3 сарын 18-ны өдөр
Олон нийгэд зарлах огноо	2026 оны 3 сарын 23-ны өдөр
Бүртгэлийн өдөр	2026 оны 4 сарын 8-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо	2026 оны 3 сарын 27-ны өдөр
Хүргүүлсэн огноо	2026 оны 3 сарын 20-ны өдөр
Хурлын даргын нэр	П.Батбаяр
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэрс	Тооллогын комиссын дарга: Ө.Бямбагэрэл Тооллогын комиссын гишүүд: Ч.Даваацэрэн, Б.Эрдэнэбилэг
Баримт, бичгийн жагсаалт	Хавсралтаар
Баримт, бичгийн хуудасны тоо	

Хурал зохион байгуулах комиссын дарга

 / П.БАТБАЯР /

2026.03.18

УЛААНСАН ХК

2026.1.18.

№ 26-2

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай*

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3 сарын 18-ны өдрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Улаансан ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2026 оны 4 сарын 29-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэрийн 17 давхарт зарлан **ХУРАЛДУУЛСУГАЙ**.
2. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 сарын 8-ны өдрөөр **ТОГТООСУГАЙ**.
3. Хурлын зарыг 2026 оны 3 сарын 23-ны өдөр Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, хоёроос доошгүй өдөр тутмын сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд зарласугай. Давтан зарыг 2026 оны 4 сарын 7-ны өдөр олон нийтэд **ЗАРЛАСУГАЙ**.
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, танилцуулга зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2026 оны 3 сарын 27-ны өдрийн дотор үнэт цаасны компаниудад **ХҮРГҮҮЛСҮГЭЙ**.
5. Хурлын даргаар Улаансан ХК-ийн Гүйцэтгэх захирал П.Батбаярыг **ТОМИЛСУГАЙ**.
6. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр **ТОМИЛСУГАЙ**. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:
Гүйцэтгэх захирал П.Батбаяр

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ө.Ашхүү

Нягтлан бодогч Б.Уянга.

7. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр Хавсралтаар, Саналын хуудасны загварыг Хоёрдугаар Хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг Гуравдугаар Хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг Дөрөвдүгээр Хавсралтаар тус тус **БАТАЛСУГАЙ**.
8. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2026 оны 4 сарын 28-ны өдрийн 15:00 цагаар тасалбар **БОЛГОСУГАЙ**.
9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр **ТОМИЛСУГАЙ**. Үүнд:
Тооллогын комиссын дарга:
 Ө.Бямбагэрэл (Ард Секюритиз ҮЦК ХХК)
Тооллогын комиссын гишүүд:
 Ч.Даваацэрэн (Ард Секюритиз ҮЦК ХХК)
 Б.Эрдэнэбилэг (Ард Секюритиз ҮЦК ХХК)
10. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст **ДААЛГАСУГАЙ**.
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал П.Батбаярт **ДААЛГАСУГАЙ**.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

Толоолон удирдах зөвлөлийн 2026 оны 3-р сарын 18-ны өдрийн

26-2 дугаар тогтоолын Хавсралт 1



**2026 ОНЫ 4-Р САРЫН 29-НИЙ ӨДӨР ХУРАЛДАХ УЛААНСАН ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
4. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах (саналын хуудас);
5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
6. ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах тухай (саналын хуудас);
7. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, батлах (саналын хуудас).

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 3-р сарын 18-ны өдрийн

26-2 дугаар тогтоолын Хавсралт 2

**УЛААНСАН ХК-ийн
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №4, 6)**



Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2026 оны 4 сарын 29-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэр 17 давхарт хуралдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэрийн томъёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
---	------------------------------------	------------	------------	------------

1	2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.			
---	--	--	--	--

2	Улаансан ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг Хавсралт 1-ийн дагуу баталсугай.			
---	--	--	--	--

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч Үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэх нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
4. Завсарласан болон балласан, залруулгатай санал авах хуудсыг хүчингүйд тооцно.
5. Саналыг саналын хуудсаар эсхүл цахимаар өгөх боломжтой.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг: _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2026 оны -р сарын өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ / _____

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

Толоолон удирдах зөвлөлийн 2026 оны 3-р сарын 18-ны өдрийн

26-2 дугаар тогтоолын Хавсралт 2

**УЛААНСАН ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №7)**



Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2026 оны 4 сарын 29-ний өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэр 17 давхарт хуралдах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№ Хурлаас гарах шийдвэрийн томьёолол Зөвшөөрсөн Татгалзсан Түдгэлзсэн

- 1 Улаансан ХК-ийн оноосон нэр “Ард Майнинг Групп”, англиар “Ard Mining Group” болон өөрчлөгдсөнтэй холбогдуулан Компанийн дүрмийн 1.4 дэх хэсгийг өөрчлөж, дүрмийн өөрчлөлтийг баталсугай
6. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
7. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч Үнэт цаасны компани (ҮЦК) дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
8. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэх нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
9. Завсарласан болон балласан, залруулгатай санал авах хуудсыг хүчингүйд тооцно.
10. Саналыг саналын хуудсаар эсхүл цахимаар өгөх боломжтой.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг: _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2026 оны -р сарын өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ / _____

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

Толоолон удирдах зөвлөлийн 2026 оны 3-р сарын 18-ны өдрийн

26-2 дугаар тогтоолын Хавсралт 3

УЛААНСАН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД



Улаансан ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 сарын 29-ний өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэр 17 давхарт болох тул хувьцаа эзэмшигчид Та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
4. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах (саналын хуудас);
5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
6. ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах тухай (саналын хуудас);
7. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, дүрэм батлах (саналын хуудас).

Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь: **2026 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр** байна.

Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

1. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудасны загвар;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.

Хувьцаа эзэмшигч та бүхэн хуралдаа итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан оролцож болох ба брокер дилерийн компаниудаар дамжуулан санал авах хуудсаар болон Ард Апп-аар саналаа урьдчилж өгөх боломжтой. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүдчийн хугацаа 2026 оны 4 сарын 28-ны өдрийн 15:00 цагт дуусна.

Мөн та бүхэн 2026 оны 4 сарын 29-ний өдрөөс өмнө ажлын өдрүүдэд ажлын цагаар өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандах, эсхүл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэр 17 давхархаягт ирж хурлын материалтай танилцах боломжтой.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд ирж болон хурал зохион байгуулах комиссын утсаар холбоо барьж авна уу.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал Тауэр 17 давхар

Утас: 88884891

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Толоолон удирдах зөвлөлийн 2026 оны 3-р сарын 18-ны өдөр
26-2 дугаар тогтоолын Хавсралт 4



**2026 ОНЫ 4 САРЫН 29-НИЙ ӨДӨР ХУРАЛДАХ
УЛААНСАН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ
АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ МАТЕРИАЛ**

1. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
2. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар;
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл.

УЛААНСАН ХК

2026. 4. 29

№ 7

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

*Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Ард инвестмент групп ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2026 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэр болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

- Улаансан ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг **БАТАЛСУГАЙ**.

ХУРЛЫН ДАРГА

П.БАТБАЯР

УЛААНСАН ХК

2026. 4. 29

№ 2

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Толоолон Удирдах Зөвлөлийн 2026 оны
төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь хэсэг, Ард инвестмент групп ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэр болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

- Улаансан ХК-ийн Толоолон Удирдах Зөвлөлийн 2026 оны төсвийг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар **БАТАЛСУГАЙ.**
- Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, Нэр дэвшүүлэх болон Цалин, Урамшууллын хороонд, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд тус тус **ДААЛГАСУГАЙ.**

ХУРЛЫН ДАРГА

П.БАТБАЯР

УЛААНСАН ХК

2026. 4.29

№ 3

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн оноосон нэр өөрчлөх, дүрэм батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Улаансан ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2026 оны 4 сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэр болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Улаансан ХК-ийн оноосон нэрийг Ард майнинг групп болгон **ӨӨРЧИЛСҮГЭЙ.**
2. Компанийн оноосон нэрийг өөрчлөхтэй холбогдуулан Компанийн дүрмийн 1.4 дэх хэсэгт дараах өөрчлөлтийг оруулж, дүрмийг **БАТАЛСУГАЙ.** Үүнд:
а/ Бүтэн нэр "Ард Майнинг Групп" ХК,
б/ Англиар: "Ard Mining Group" Joint Stock Company
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, эрх бүхий бүртгэлийн байгууллагад холбогдох өөрчлөлтийг бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал П.Батбаярт **ДААЛГАСУГАЙ.**

ХУРЛЫН ДАРГА

П.БАТБАЯР